

Агуулга

	<u>Ерөнхий зүйл</u>	<u>хуудас</u>
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс.....	2
ҮАГ-ын нэгдүгээр газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<i>Захирал</i>	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	3
<i>Д.Ганбилэг</i>	Аудитын стандартын талаархи мэдэгдэл.....	3
<u>Аудитын менежер</u>		
<i>Ж.Батсайхан</i>	<u>Бүлэг 1</u>	
<u>Ахлах аудитор</u>	Зээлийг нөхөн төлүүлж сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажил хийгдээгүй байна.....	4-8
<i>Г.Нямдорж</i>		
<u>Аудитор</u>	<u>Бүлэг 2</u>	
<i>И.Туяа</i>	СТС сургалтын зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийг холбогдох хууль, эрхийн актын дагуу бүрэн хийжээ.....	9-11
<u>Шинжээч</u>		
<i>Ц.Цолмон</i>	<u>Бүлэг 3</u>	
<i>У.Баярмаа</i>	Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.....	12-17
<u>Хянасан:</u>		
<i>Ж.Батсайхан</i>		
2007 оны 12 дугаар сар		
<u>Тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү:</u>	<u>Дүгнэлт</u>	18
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	Холбогдох байгууллагын санал	19-22
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261740 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Саналд өгөх тайлбар	23
	<u>Зөвлөмж</u>	24
	Хавсралт	25
	Ерөнхий аудиторовын тушаал.....	26

Товчилсон үгс

УИХ	Улсын Их Хурал
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ЗГ	Засгийн газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
СТС	Сургалтын төрийн сан
МУИС	Монгол улсын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
МУБИС	Монгол улсын багшийн их сургууль
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
БОЯ	Байгаль орчны яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ҮХЯ	Үйлдвэр худалдааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЭСЯ	Элчин сайдын яам
УЗ	Удирдах зөвлөл
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сургалтын төрийн сангийн зарим үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- Сургалтын төрийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт
- Сургалтын төрийн сангийн хөрөнгийн зарцуулалт
- Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа байдал

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

- Дээд боловсролын тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Засгийн газрын 2000 оны 96,158,201 дүгээр тогтоолууд
- “Журам шинэчлэн батлах тухай” БСШУ-ны сайд, СЭЗ-ийн сайдын 2001 оны 310/290 дүгээр тушаал

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитын явцад асуудлыг шинжлэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар мэдээ гаргуулах, харьцуулалт хийх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Бүлэг 1

Зээлийг нөхөн төлүүлж сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажил хийгдээгүй байна

1.1 СТС-гаас сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийг 2004-2006 онд дараахь журмын дагуу олгожээ. Үүнд:

- ЗГ-ын 2000 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”
- ЗГ-ын 2000 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан “Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам”
- ЗГ-ын 2000 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам”
- БСШУ-ны сайд, СЭЗ-ийн сайдын 2001 оны 310/290 дүгээр тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”

1.2 СТС-гаас 2005-2006, 2006-2007 оны хичээлийн жилд олгосон зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагчдын тоог дараахь хүснэгтээр харуулав:

Үзүүлэлт	Хичээлийн жилийн эхэнд зээл, тусламжид хамрагдаж байсан оюутны тоо	2005-2006				2006-2007			
		Нэмэгдсэн	хасагдсан	Зээл, тусламж		Нэмэгдсэн	хасагдсан	Зээл, тусламж	
				авах	авсан			авах	авсан
Дүн	47053	8939	10200	45792	46003	9895	10648	45250	45546

1.3 БСШУ-ны сайд, СЭЗ-ийн сайдын тушаалаар тогтоосон хяналтын тооноос 2005-2006 оны хичээлийн жилд 140, 2006-2007 оны хичээлийн жилд 200 оюутанд сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж илүү олгожээ.

1.4 СТС-гийн сургалтын зээл, буцалтгүй тусламжийг санхүүжүүлэхээр 2004 онд 13.2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн боловч 47.3 мянган суралцагчдад 15.5 тэрбум төгрөгийн зээл, буцалтгүй тусламж олгохоор гэрээ хийсэн ба үүнээс шалтгаалан үүссэн 2.3 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн зээлийн өрийг 2006 оны төсвийн тодотголоор санхүүжилтийг нэмэгдүүлэн шийдвэрлэсэн байна.

1.5 2005-2006 онд УИХ, ЗГ-ын гишүүдээр уламжлуулан ирүүлсэн 1900 гаруй иргэдийн хүсэлт өргөдлийг шийдвэрлэсэн нь СТС-гийн батлагдсан төсвийн гүйцэтгэл хэтрэхэд мөн нөлөөлжээ.

1.6 Боловсрол болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдын хяналтын тоог жил бүрийн 5 дугаар сард мэргэжил тус бүрээр батлах ёстой атал 2005 онд 7 дугаар сарын 4-нд, 2006 онд 8 дугаар сарын 25-нд баталж ЗГ-ын 2000 оны 96 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

1.7 Хяналтын тоог 2004 онд 8905-аар тогтоосон бол 2005-2006 онд 5600 оюутнаар тогтоож, БСШУЯ-наас их, дээд сургууль, коллежид суралцах томилолт авсан оюутны 25.5-21,2 хувийг сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид хамруулжээ. Хяналтын тоонд төрийн албан хаагчийн гэр бүлээс суралцагч оюутныг хамруулж тогтоодоггүй, мөн бодит нөхцөл байдлыг харгалзаагүйгээс олон оюутан СТС-гийн зээл, тусламжид хамрагдаж чадахгүй, их дээд сургуулиуд ч ЗГ-ын 2000 оны 96, 158, 201 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлж чадахгүй болжээ. Тухайлбал төрийн өмчийн дараахь их сургуулиудад хүсэлт гаргасан суралцагчдын 57.3 хувь нь сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагджээ.

Сургуулийн нэр	сургалтын төрийн сангийн зээл, буцалтгүй тусламжид		
	Хамрагдах хүсэлт гаргасан	Хамрагдсан	хувь
МУИС	962	504	52.3
ШУТИС	1081	728	67.3
МУБИС	977	510	52.2
ЭМШУИС	239	125	52.3

1.8 БСШУ-ны сайд, СЭЗ-ийн сайдын 2001 оны 310/290 дүгээр тушаалаар батлагдсан журамд өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын тоог ЗГ-аар батлуулахаар заасан атал оюутнуудын тоог бус шаардагдах сургалтын төлбөрийн дүнг улсын төсвөөс баталж өгдөг нь сургалтын зээл, буцалтгүй тусламжийн нийт дүнгийн 19.0 хувийг эзэлж байна.

1.9 Гэгээрлийн сайдын 1999 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Их сургууль, коллежийн төсөв зохиох, сургалтын төлбөрийг тодорхойлох үлгэрчилсэн аргачлал”-д их сургууль, коллежийн зардлыг дараахь эх үүсвэрээр санхүүжүүлэх, сургалтын төлбөрт хамаарах зардлын дүнг нийт кредит цагийн тоонд харьцуулан тогтоосон нэг кредит цагийн үнэлгээг үндэслэн сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохоор заажээ.

Зардлын гол бүлгүүд	Санхүүжүүлэх эх үүсвэр
сургалттай холбоотой зардал	сургалтын төлбөр
захиргаа аж ахуйн зардал	сургалтын төлбөр
Ашиглалтын зардал	улсын төсөв, сургалтын төлбөр
оюутны үйлчилгээний зардал	оюутны үйлчилгээний хураамж
эрдэм судлалын ажлын зардал	сургалтын зардал, шинжлэх ухаан технологийн сан, хувийн секторын санхүүжилт
сургууль хөгжүүлэх хөтөлбөрийн зардал	улсын төсөв, хувийн секторын санхүүжилт, сургалтын төлбөр
үндсэн бус үйл ажиллагааны зардал	үндсэн бус үйл ажиллагааны орлого

1.10 Гэтэл дээрх тушаалыг мөрдөж ажиллаагүй, боловсронгуй болгох ажлыг хийгээгүйгээс сургалтын төлбөрийг төрийн өмчийн их сургууль бүр өөрөөр, нэгдсэн аргачлалгүй тооцон тогтоож байна.

1.11 Тухайлбал, ШУТИС нэг кредитийн үнэлгээг тогтоохдоо, урьд оны санхүүгийн хүрсэн түвшин, сургуулийн УЗ-ийн хурлаар баталсан ирэх хичээлийн жилийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, орлого, зарлагын төсөв, мөнгөний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан инфляцийн түвшингийн хувь, оюутны зөвлөлийн саналыг харгалзан:

- 1 дүгээр курсын оюутны сургалтын төлбөрийг: Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, зардлын төсвийн дагуу тогтоогдсон зардлаас, 2-5 дугаар курсын суралцагчдын төлбөрийн инфляцийн түвшингээр өсгөсөн орлогыг хасан нэгдүгээр курсэд суралцах оюутны тоонд хувааж;

- 2-5 дугаар курсын оюутны сургалтын төлбөрийг: урьд жилийн сургалтын төлбөрийн дүнг инфляцийн түвшингээр өсгөн тогтоож, сургалтын төлбөрийн өсөлтийг дараагийн курсийн суралцагчдад ногдуулан тогтоожээ.

1.12 МУБИС 2006-2007 оны хичээлийн жилд дээрх үзүүлэлтүүд болон бусад ижил төстэй сургуулиудын жишгийг харгалзан, зөвхөн шинээр элсэгчдийн төлбөрийг шинэчлэн тогтоож бусад курсын оюутнууд урьд төлж байсан төлбөрөө үргэлжлүүлэн төлөх, нийт дүнгээрээ сургалтын төлбөрөө 9 хувиар өсгөхөөр, ЭМШУИС 2007-2008 оны хичээлийн жилд нийт зардлыг зардлын төвүүд буюу сургууль тус бүрээр тооцон оюутнуудын тоонд хуваах гэх мэтээр сургалтын төлбөрийг тогтоож иржээ.

1.13 Дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг баримтлан сургалтын төлбөрийн хэмжээг тогтоон мөрдөхийг ЗГ-ын 2004 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 187 дугаар тогтоолоор төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн захирал, удирдах зөвлөлийн дарга нарт үүрэг болгосон ба 2005-2006 онд төрийн өмчийн их сургуулиуд энэ жишгээс 57.0-158.7 мянган төгрөгөөр илүү тогтоожээ.

1.14 ЗГ-ын тогтоолоор баталсан нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишиг, сургуулийн УЗ-өөр тогтоосон болон төсөвт зардлаар тооцсон нэг суралцагчийн сургалтын төлбөрийн дунджийг төрийн өмчийн дараахь сургуулиудаар авч үзэн харьцуулав:

Сургуулийн нэрс	Хичээлийн жил	Суралцах оюутан	төсөвт зардлын гүйцэтгэл	Сургуулиас тогтоосон сургалтын төлбөрийн		Сургуулиас тогтоосон сургалтын төлбөрийн нэг суралцагчийн дунджийн зөрүү / дутуу -, илүү + /	
				нийт дүн	нэг суралцагчийн дундаж	төсөвт зардлаар тооцсоноос	ЗГ-ын тогтоолоор баталснаас
МУИС	2005-2006	11333	3,900,340.5	4.159.168.0	367.0	22.8	57.0
	2006-2007	11336	5,310,960.8	5.129.178.0	452.5	- 16.0	142.5
ШУТИС	2005-2006	18399	5.191.188,3	7.637.271.3	415.1	133.3	105.1
	2006-2007	18732	7.356.188,3	8.780.815.8	468.7	76.0	158.7
МУБИС	2005-2006	6948	2.105.398,2	2.366.288.9	340.5	37.4	55.5
	2006-2007	8983	2.503.512,5	3.293.292.6	366.6	87.9	81.6
ЭМШУИС	2005-2006	3523	1.989.055,2	1.502.260.0	426.4	- 138.2	96.4
	2006-2007	3714	2.344.125,0	1.580.117.0	425.4	- 205.7	95.4

1.15 Хүснэгтээс үзвэл 2005-2006 болон 2006-2007 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийг батлагдсан төсөвт зардлаас МУБИС 37.4-87.9 мянган төгрөгөөр, ШУТИС 133.3-76.0 мянган төгрөгөөр илүү тогтоожээ.

1.16 “Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-д эдгээр оронд суралцагчдад олгох сургалтын болон тэтгэлгийн зардлыг суралцах сургуулиас нь ирсэн бичиг баримт, бүрдүүлсэн материалыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан үзэж, шаардагдах зардлыг СТС-гийн дансанд шилжүүлэхээр заасны дагуу суралцагчийн нэг жилийн зардалд 3.1-33.8 мянган ам.доллар олгож байжээ.

1.17 1999 оноос нэг суралцагчид олгох сургалтын зээлийн хэмжээг 16.0 мянган ам.доллараар тогтоон мөрдөж ирсэн боловч энэ талаар Санхүү, төсвийн болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан ёсны шийдвэр алга байна.

1.18 СТС сургалтын зээл, буцалтгүй тусламжийг нэр төрөл тус бүрээр төлөвлөж, батлуулахаар хүргүүлж буй боловч СЯ санхүүжүүлэх дүнг зөвхөн сургалтын зээл, буцалтгүй тусламж гэсэн нэр төрлөөр баталж иржээ. СЯ 2005-2006 онд жил бүр сургалтын зээлд 8.6 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжид 3.9 тэрбум төгрөг, нийт 12.5 тэрбум төгрөг зарцуулахаар төсөв баталсан байна.

1.19 “Их, дээд сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”-д заасны дагуу олгосон зээл, түүний хүүгийн төлбөрөөс орох орлогыг СТС-гийн эх үүсвэрт тооцон төлөвлөж байгаагүй, “Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-д энэ зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт олгосон зээл, түүний хүүгийн төлбөрийн орлогыг оруулж тооцох талаар заагаагүй байна.

1.20 ЗГ-ын 2004 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 187 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчийн их дээд сургууль, коллежид дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг үндэслэн 2006 оны байдлаар СТС-гаас МУИС-д суралцагчийн сургалтын төлбөрийн 68 хувийг, ШУТИС, МУБИС-д суралцагчийн сургалтын төлбөрийн 66 хувийг, ЭМШУИС-д суралцагчийн сургалтын төлбөрийн 77 хувийг хариуцаж, ялгавартай хандсан байна.

1.21 СТС-гаас олгосон сургалтын зээлийн авлагын үлдэгдэл 2006 оны эцсийн байдлаар 38.9 тэрбум төгрөгт хүрч, үүний 63.5 хувь буюу 24.7 тэрбум төгрөг нь гадаадын, 22.1 хувь буюу 8.6 тэрбум төгрөг нь дотоодын их, дээд сургуульд суралцагчдад олгосон зээлийн авлага, 14,4 хувь буюу 5.7 тэрбум төгрөг нь өндөр хөгжилтэй оронд суралцагчдын зээлийн хүүгийн авлага байна.

/сая төгрөгөөр/

Авлагын төрөл	авлагын үлдэгдэл			урьд оноос нэмэгдсэн, хорогдсон	
	2004.12.31	2005.12.31	2006.12.31	2005 онд	2006 онд
Гадаадад суралцагчдаас авах авлага	20,046.0	23,089.7	24,705.4	3,043.7	1,615.7
Дотоодын их, дээд сургуульд суралцагчдаас авах авлага	3,887.3	5,949.6	8,564.0	2,062.3	2,614.4
Хүүгийн авлага	3,283.2	5,020.9	5,691.6	1,737.7	670.7
ДҮН	27,216.5	34,060.2	38,961.0	6,843.7	4,900.8

1.22 Дотоодын их, дээд сургуульд суралцагчдад олгосон сургалтын төлбөрийн зээлээс 2004 онд 9 суралцагчийн 3.8 сая төгрөг, 2005 онд 5 суралцагчийн 4.2 сая төгрөг, 2006 онд 11 суралцагчийн 7.1 сая төгрөгийн зээл төлөгдсөн нь жил бүр 2.1-2.2 тэрбум төгрөгийн сургалтын зээл олгож байгаатай харьцуулбал хангалтгүй байна.

1.23 2003-2004 оны хичээлийн жилээс өмнө СТС-гийн зээлээр суралцаж дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн 21.0 мянган төгсөгчийн 8.2 тэрбум төгрөгийн зээл, түүний хүүгийн төлбөрийг ЗГ-ын 2004 оны 22 дугаар тогтоолоор чөлөөлжээ.

1.24 Сургалтын зээл, түүний хүүг төлүүлэлгүй чөлөөлсөн нь сургалтын зээлийн агуулга, ач холбогдлыг бууруулж, төлөлтөд муугаар нөлөөлж байна.

1.25 1997-2006 онд өндөр хөгжилтэй 31 оронд суралцсан 923 хүний 294 нь сургуулиа төгсөж эх орондоо ирсэн, 319 нь захиалагч байгууллагатай болон СТС-тай байгуулсан гэрээгээ зөрчин эх орондоо ирээгүй, 270 нь одоо суралцаж байна.

1.26 Дээрх хугацаанд өндөр хөгжилтэй оронд суралцсан 731 магистр, 78 докторант, 29 аспирант, 80 бакалавр, 39 мэргэжил дээшлүүлэгчид олгосон 24.8 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн зээлээс 0.4 хувь нь буюу 38 хүний 104.5 мянган ам. доллар төлөгджээ.

1.27 Төгсөж ирсэн 294 хүний 225 нь захиалгат байгууллагадаа, 38 нь төрийн бус байгууллагад ажиллаж, 31 нь тодорхой ажил эрхлээгүй байна.

1.28 Өндөр хөгжилтэй оронд төрийн 27 байгууллагын захиалгаар суралцагчдын 10.1-66.7 хувь, тухайлбал, УИХТГ-ын захиалгаар суралцсан 27 хүний 10 нь, ЕТГ-ын захиалгаар суралцсан 3 хүний 2 нь, БОЯ-ны захиалгаар суралцсан 27 хүний 14 нь, ЭМЯ-ны захиалгаар суралцсан 74 хүний 29 нь, НХХЯ-ны захиалгаар суралцсан 13 хүний 5 нь, УМХГ-ын захиалгаар суралцсан 6 хүний 2 нь, ҮХЯ-ны захиалгаар суралцсан 68 хүний 29 нь, ГХЯ-ны захиалгаар суралцсан 32 хүний 15 нь, Нийслэлийн ЗДТГ-ын захиалгаар суралцсан 6 хүний 4 нь сургуулиа төгссөн ч эх орондоо ирээгүй, 7,723.2 мянган ам.долларын сургалтын зээлийн төлбөрөө төлөөгүй байна.

1.29 БСШУЯ-ны захиалгаар суралцсан 279 суралцагчийн 113 нь сургуулиа төгссөн ч эх орондоо ирээгүй, тэдний авсан зээл 2,782.6 мянган ам.доллар байгаа нь СТС-гаас өндөр хөгжилтэй оронд суралцагчдад олгож буй сургалтын зээлийн бүтэн жилийн санхүүжилтээс илүү байна.

1.30 СТС-гаас сургалтын зээлийн төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэхээр 2003-2006 онд хуулийн ажилтан авч ажиллуулах, захиалагч байгууллагуудад албан тоот хүргүүлэх, барьцаалсан хөрөнгийг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт тэмдэглүүлэх зэрэг ажил зохиож, төгсөж ирээд бүртгүүлээгүй 80 гаруй хүнийг бүртгэн, 200 гаруй суралцагчтай уулзсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.


1.31 “Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2.7-д сургалтын зээлийн төлбөрийг барагдуулах асуудлыг СТС хариуцах, суралцагчидтай байгуулсан гэрээний 3.3-д захиалагч хариуцан төлүүлж СТС-д шилжүүлэхээр заасан нь зээл төлүүлэх ажлыг сулруулан хариуцах эзэнг тодорхой бус болгожээ.

Бүлэг 2


СТС сургалтын зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийг холбогдох хууль, эрхийн актын дагуу бүрэн хийжээ

2.1 СТС их, дээд сургуулиудтай санхүүжилтийн тооцоог улирал бүр хийж СЯ-аар хянуулан, 2004-2006 онд жил тутам 5.6-4.9 тэрбум төгрөгийн сургалтын зээл, 9.8-10.1 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжийг төрийн сан дахь төгрөгийн 90001504 тоот, ам.долларын 3332407 тоот дансуудаар дамжуулан олгожээ.

2.2 СТС-гийн нийт санхүүжилтийн 63.0-74.8 хувийг сургалтын зээл олгоход зарцуулж, буцалтгүй тусламжийн эзлэх хувь буурч иржээ. СТС-гийн сургалтын зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдын төлбөрийн санхүүжилтийг харуулав:



2.3 Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдад жил бүр 2.3-3.4 тэрбум төгрөгийн сургалтын зээл олгожээ. Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын сургалтын төлбөр, тэтгэлгийн санхүүжилтийг харуулав:



2.4 СТС-гаас 2004-2006 онд зарцуулсан буцалтгүй тусламжийн 44.7-41.7 хувийг төрийн албан хаагчийн гэр бүлээс их, дээд сургууль, коллежид суралцаж буй нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцахад, нийт хөнгөлөлттэй зээлийн 57.1-60.6 хувийг өндөр хөгжилтэй орны магистр, аспирантур, докторантурт төрийн ажилтнуудыг суралцуулахад буюу сангийн хөрөнгийн дийлэнх хувийг төрийн албан хаагчийг дэмжихэд зарцуулсан байна.

2.5 Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй болон нэн ядуу өрх, тахир дутуу суралцагчдын тоо нэмэгдсэнээс шалтгаалан СТС-гаас тэдэнд олгосон сургалтын буцалтгүй тусламж 2004-2006 онд 435.9-883.8 сая төгрөгт хүрч өсжээ.

2.6 Төрөл бүрийн олимпиад, уралдаан тэмцээнд байр эзэлсэн болон амжилттай суралцагчдад 2004-2006 онд 42.2-44.3 сая төгрөг буюу нийт буцалтгүй тусламжийн 0.4 хувийг олгосон нь СТС-гаас олгож буй хөрөнгө оюутны суралцах идэвхийг өрнүүлэх хөшүүрэг тэр бүр болохгүй байгааг харуулж байна.

2.7 СТС-гаас сургалтын зээл, буцалтгүй тусламжид зарцуулахаар батлагдсан төсөвт зардлыг 2004-2005 онд 23.3-25.5 хувиар хэтрүүлсэн нь урьд жилүүдийн гүйцэтгэлийн дунджаас багаар хянаж баталснаас шалтгаалжээ. Сургалтын зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтийг төлөвлөсөн, хянасан байдлыг зээл, тусламжийн нэр төрлөөр гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулав:

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт		Санхүүжилт								
		2004 он			2005 он			2006 он		
		төлөвлөгөө	хянаж баталсан	гүйцэтгэл	төлөвлөгөө	хянаж баталсан	гүйцэтгэл	төлөвлөгөө	хянаж баталсан	гүйцэтгэл
ЗГ-ын 96-р тогтоол	буцалтгүй тусламж	724.1		435.9	747.4		737.4	815.7		883.8
	шагнал, олимпиад	45.2		44.3	42.0		43.4	43.5		42.2
ЗГ-ын 158-р тогтоол	нэн ядуу	3,328.8		3,143.7	3,163.2		3,511.5	3,195.6		3,154.3
	малчин	1,201.9		1,524.7	1,358.2		1,687.1	1,338.3		1,292.2
	3-н суралцагч	288.9		289.0	277.9		284.4	277.1		256.5
ЗГ-ын 201-р тогтоол	ТАХ-чийн гэр бүлд буцалтгүй тусламж	4,343.3	3,923.3	4,394.4	4,495.5	3,923.3	4,492.3	4,526.8	4,147.3	4,489.5
Буцалтгүй тусламжийн дүн		9,932.2		9,832.0	10,084.2		10,756.1	10,197.0		10,118.5
ЗГ-ын 96-р тогтоол	хөнгөлөлт -тэй зээл	2,364.8		2,235.2	2,200.4		2,161.3	2,125.1		2,078.7
БСШУ-ны сайд, СЭЗ-ийн сайдын 310/290 тушаал	Өндөр хөгжилтэй орны магистр, докторантурт суралцагч	2,894.3		3,437.9	2,876.3		2,876.4	2,876.3		2,821.4
Хөнгөлөлттэй зээлийн дүн		5,259.1		5,673.1	5,076.7		5,037.7	5,001.4		4,900.1
Сургалтын зээл, буцалтгүй тусламжийн нийт дүн		15,191.3	12,567.6	15,505.1	15,160.9	12,585.5	15,793.8	15,198.4	15,109.5	15,018.6

2.8 Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдын сургалтын төлбөрийг их сургууль, коллежид олгохдоо кредит цагийн биелэлтийг харгалзаагүй байна.

2.9 Төрийн албан хаагчийн гэр бүлээс их, дээд сургууль, коллежид суралцаж буй нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцах зардлын төсвийг 2004-2006 онд 342.2-569.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь төсвийг бодитой хянаж батлаагүйг харуулж байна.

2.10 СТС суралцагчдын шилжих хөдөлгөөнөөс хамаарсан санхүүжилтийн зохицуулалт, сунгалт, шилжих хөдөлгөөний тайлан гаргах, олгосон санхүүжилтийг их, дээд сургууль, коллежуудад шалгах ажлыг жилд 3 удаа хийж байна.

2.11 Сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан жилийн чөлөөтэй 2703, хасагдсан 610, шилжсэн, гэрээгээ зогсоосон 100 гаруй суралцагчдын шилжих хөдөлгөөнийг тухай бүр тооцон 446,5 сая төгрөгийн суутгалын тооцоо хийгджээ.

2.12 ТБУСТХ-ийн 34.1-д “Санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно” гэж заасан. Гэтэл СТС, их, дээд сургуулиуд сургалтын зээл, буцалтгүй тусламжид зарцуулах хөрөнгө, сургалтын төлбөрийн төлөвлөлтийг хичээлийн жилээр хийж байгаа нь түүнд тавих хяналтыг хүндрүүлж байна.

2.13 СТС-гийн харилцах дансдын гүйлгээг зарим их, дээд сургуулиудын санхүүгийн тайлан балансын үзүүлэлтүүдтэй тулган шалгасан ба их, дээд сургуулиудад олгосон сургалтын зээл, буцалгүй тусламжийн зарцуулалтад СТС-гаас тавих хяналтыг сайжруулах, зарцуулсан хөрөнгийн эцсийн үр дүнг тооцоход анхаарах шаардлагатай байна.

2.14 Улсын төсвөөс сургалтын зээлд зориулан олгосон санхүүжилтийг улсын төсвийн нэгдсэн санхүүгийн тайланд тусгай зориулалтын бусад сан дансны зардлаар бүртгэсэн атал, СТС-гийн санхүүгийн тайланд улсын төсвөөс урт хугацаат зээлээр бүртгэсэн нь буруу байна. Иймд сургалтын зээлийн үлдэгдлийг СТС-гийн хөрөнгийн эх үүсвэр гэж үзэн хуримтлагдсан үр дүнгийн дансаар бүртгэх нь зүйтэй гэж үзэв.

2.15 ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд СТС-гийн хөрөнгийн нэг эх үүсвэр нь сургалтын зориулалттай зээлийн төлбөр байхаар заасан атал суралцаж төгсөгчдийн 2004-2006 онд төлсөн сургалтын зээлийн төлбөр 15.2 сая төгрөг, 104.5 мянган ам.долларыг улсын төсвийн дансанд оруулжээ.

Бүлэг 3

Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаа нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна

3.1. СТС 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр 200 гаруй байгууллага, 183 их, дээд сургууль, коллежтэй хамтран ажиллаж, сургалтын зээл, буцалтгүй тусламжийг санхүүжүүлэх, суралцагсдын гэрээг хянах, сунгах ажлыг зохион байгуулж байна.

3.2. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын дэлгэрэнгүй бүртгэлийг СТС-гийн мэдээллийн нэгдсэн системд 2004 оны 8 дугаар сард оруулснаар зээл, тусламжид хамрагдагсдын давхардлыг арилгаж, санхүүжилтэд тавих хяналт сайжирчээ.

3.3. Сургалтын зээл, буцалтгүй тусламжаар суралцах иргэдийн тоог орон нутгийн ажиллах хүчний хэрэгцээнд үндэслэн аймаг, нийслэлээр тогтоох журам баталж хэрэгжүүлэх, суралцаж төгсөгчдийг орон нутагт томилон ажиллуулах заалтыг Боловсролын тухай хуульд оруулахаар ажиллаж байна.

3.4. 2004 онд батлагдсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Төрөөс суралцагчдад үзүүлж байгаа сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн тогтолцоог шинэчлэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд:

- ЗГ хоорондын хэлэлцээр, буцалтгүй тусламжийн хүрээнд гадаад оронд суралцагчдын дотор инженер, технологийн мэргэжил эзэмшигчдийн хувийн жинг жил бүр нэмэгдүүлэх;
- Их, дээд сургууль, коллежид сурч байгаа өнчин, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нарт сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох;
- Их, дээд сургууль, коллежид суралцагчдад олгох хөнгөлөлттэй зээлийг бусад орны жишгээр банкны зээлийн тогтолцоонд оруулах асуудлыг судлан боловсруулж шийдвэрлэх;
- Мэргэжлийн чиглэл, хяналтын тооны дагуу гадаадад суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах, суралцуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөжээ.

3.5. Сургалтын төлбөрийн зээл олгох ажлыг банкны системээр дамжуулан гүйцэтгэх санаачлагыг анх 1996 онд ЗГ-аас дэвшүүлсний дагуу БСШУЯ төсөл боловсруулсан боловч одоогоор энэ ажил хэрэгжээгүй байна.

3.6. СТС-гийн үйл ажиллагааг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, ЗГ-ын 2000 оны 96, 158, 201 дүгээр тогтоолууд, Гэгээрлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2001 оны 310/290 дүгээр тушаал, Сургалтын төрийн сангийн дүрэм зэрэг хууль, эрх зүйн актуудаар зохицуулж байгаа ба сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, төлүүлэх журмыг 1995 оноос хойш 3 удаа өөрчилж боловсронгуй болгожээ.

3.7. Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагчийг сурлагадаа тодорхой амжилт гаргасан байхыг шаарддаг байснаа 2002 оны 10 сараас хүчингүй болгосон нь сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн агуулга, ач холбогдлыг бууруулсан ба одоогийн мөрдөж буй журамд зээлийн төлж эхлэх хугацааг тодорхой болгох, зээл төлөлтийг урамшуулах заалт оруулах шаардлагатай байна.

3.8. Боловсролын тухай хуулийн 33.6-д “Суралцагсад хөнгөлөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор сургалтын төрийн сан ажиллуулна. Энэ сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар тогтооно”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.4-д “Сургалтын төрийн сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан боловч энэ журмыг боловсруулаагүй, өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журмыг БСШУ-ны сайдын, санхүүжүүлэх журмыг БСШУ-ны сайд, СЭЗ-ийн сайдын тушаалаар батлан мөрдүүлсэн байна.

3.9. СТС-гийн үүрэг зорилгыг тодорхой заагаагүй, хөрөнгийг зарцуулах журам гараагүйгээс шалтгаалан оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад тусламж үзүүлэх анхны зорилго гажиж сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдагсдын хүрээг хэт өргөжүүлэн, төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг хүртэл хамруулах болсон байна.

3.10. СТС-гаас сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох үйл ажиллагаа 1993-1995 онд оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудад тусалж дэмжих чиглэлээр эхэлсэн бол 1996-1999 онд нэн ядуу болон амьдралын түвшин доогуур айлын оюутан хүүхдэд, 2000 оноос хойш ядуу, өнчин, малчин, бага орлоготой, төрийн албан хаагчийн хүүхдэд зээл, буцалтгүй тусламж олгох, 2003 оноос сумдад төрийн албан хаагч бэлтгэх зардал гэх мэтээр хүрээ нь улам тэлж 1994-2004 онд сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдагсад 8.0 мянгаас 40.0 гаруй мянга болтлоо өсжээ.

3.11. Сургалтын зээл, буцалтгүй тусламжийн талаар ЗГ-аас 7 удаа тогтоол гаргаж зээл, тусламжид хамрагдах оюутнуудын хамрах хүрээг тэлжээ. Үүнийг дараахь хүснэгтээр харуулав:

ЗГ-ын 1993 оны 107 дугаар тогтоол:	ЗГ-ын 1995 оны 194 дүгээр тогтоол:	ЗГ-ын 1997 оны 179 дүгээр тогтоол:	ЗГ-ын 2000 оны 96 дугаар тогтоол:	ЗГ-ын 2000 оны 158 дугаар тогтоол:	ЗГ-ын 2000 оны 201 дүгээр тогтоол:
Буцалтгүй тусламж <ul style="list-style-type: none"> Холбогдох яамдын захиалгын дагуу суралцагсдын сургалтын төлбөр Шаардлага-тай оюутнуудад олгох стипенд Онцгой авьяастай оюутнуудын стипенд Хоёр улсын гэрээгээр суралцаж буй гадаад оюутнуудын стипенд 	Буцалтгүй тусламж <ul style="list-style-type: none"> Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагч Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуу суралцагч Хөнгөлөлттэй зээл <ul style="list-style-type: none"> Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн буюу хагас өнчин суралцагч Магистрантын сургалтын төлбөр, багшийн мэргэжлээр суралцагчийн тэтгэлэг Бага орлоготой өрхийн 	Буцалтгүй тусламж <ul style="list-style-type: none"> Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуугийн группэд орсон суралцагч Сургалт, эрдэм шинжилгээний ажилд өндөр амжилт гаргасан онцгой авьяас чадвартай суралцагчийн сургалтын төлбөрийг 5 дугаар улирлаас эхлэн Олон улсын уралдаан, олимпиадаас эхний 3 байр эзэлсэн суралцагчийн эхний 2 жилийн Хөнгөлөлттэй зээл <ul style="list-style-type: none"> Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон гишүүдтэй өрхийн 2-оос илүүгүй суралцагч Оюуны болон хөдөлмөрийн чадвараа алдсан хараагүй, дүлий иргэд бүхий өрхийн 1, 	Буцалтгүй тусламж <ul style="list-style-type: none"> Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн тахир дутуу суралцагч Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хагас өнчин суралцагчийн жилийн төлбөрийн 150,0 мянган төгрөгийг Хөнгөлөлттэй зээл <ul style="list-style-type: none"> Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагч Оюуны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрхийн суралцагч Эцэг эх нь 2- 	Буцалтгүй тусламж <ul style="list-style-type: none"> ҮСГ-аас тогтоосон бүсийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн 40 хувиас бага орлоготой нэн ядуу 200 хүртэл бог малтай малчин өрхийн суралцагч 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа өрхийн суралцагч 2001 оны 195 дугаар тогтоол <ul style="list-style-type: none"> 500 хүртэл бог малтай малчин өрх Амьжиргааны доод түвшингийн 60 хувиас бага орлоготой ядуу өрх Сумдаас ирсэн захиалгын дагуу багш, эмчээр 	Буцалтгүй тусламж <ul style="list-style-type: none"> Төрийн албан хаагчийн их, дээд сургуульд суралцаж байгаа 1 хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даах

	<p>суралцагч</p> <ul style="list-style-type: none"> • Гадаад орны мэргэжлийн сургуульд суралцагчийн сургалтын төлбөр, замын зардал 	<ul style="list-style-type: none"> • хагас өнчин суралцагч • Багшийн мэргэжлээр суралцагч • ЗГ-ын гэрээгээр гадаадын суралцагч 	<p>уулаа өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч</p> <ul style="list-style-type: none"> ▪ Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хагас өнчин суралцагч ▪ Бакалаврын 3.5-аас дээш голч дүнтэй төгссөн магистрантур, докторантур ▪ ЗГ-ын гэрээгээр гадаад оронд суралцагч 	<p>ажиллахаар гэрээ хийсэн суралцагчийн 2 жилийн төлбөр</p> <p>2002 оны 207 дугаар тогтоол</p> <ul style="list-style-type: none"> ▪ 700 хүртэл бог малыг малчин өрх
--	---	---	---	---

3.12. Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж авсан зарим суралцагч хангалтгүй суралцаж, сургуулиа орхисноос зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгө үргүй зарцуулагдаж, сургуулиа орхигсдын сургалтын төлбөрийн хэмжээгээр их, дээд сургуулиуд СТС-д өртэй үлдэж сургалтын үйл ажиллагааны санхүүжилтэд хүндрэл учирч байгаа нь сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдагсдын сурах чадвар, идэвхийг дэмжсэн бодлого дутагдаж байгааг харуулж байна.

3.13. Өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах зөвлөл 1999 оноос ажиллаж байгаа боловч, БСШУ-ны сайдын 2001 оны 117 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”-д мэргэжлийн болон хэлний шалгалт авч сонгон шалгаруулалт хийх комиссын тухай зааснаас бус шалгалт өгдөггүй иргэдийн суралцахаар гаргасан хүсэлтийг авч хэлэлцэн шийдвэр гаргадаг зөвлөл ажиллах тухай заагаагүй байна.

3.14. Энэ зөвлөл ажиллах дүрэмгүй, шударга, ил тод ажиллаагүйн зэрэгцээ захиалагч байгууллагуудаас ирүүлсэн материалыг авч хэлэлцэх ёстой атал зохих шалгуурыг хангаагүй олон иргэдэд давуу байдал олгон тэдний хүсэлтийг шууд хүлээн авч шийдвэрлэн БСШУ-ны сайдын 2005 оны 52 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчжээ.

3.15. Тухайлбал, хувийн хүсэлтийнх нь дагуу 1991-2002 онд ХБНГУ-д бакалавр, магистрийн сургалт дүүргэн одоо тус улсад ажиллаж байгаа иргэн Д.Одонцэцэгт докторын 3 жилийн сургалтын төлбөрт 24.0 мянган евро олгох, 2002 оноос Англи улсад коллеж, их сургуульд суралцаж байгаа Т.Энэрэлд бакалаврын 2 жилийн сургалтын төлбөрт 34.0 мянган ам.доллар олгох шийдвэрийг тус зөвлөл гаргаж байжээ.

3.16. Мөн уг зөвлөлийн шийдвэрээр сонгон шалгаруулалтад тэнцээгүй хүмүүст сургалтын төлбөрийн зээл олгосон, сонгон шалгаруулалтад орсон мэргэжлээс өөр мэргэжлээр явах, нэг хүнд дахин тушаал гаргах зэргээр журам зөрчсөн байна. Үүнд:

- Соёлын менежментийн чиглэлээр сонгон шалгаруулалтад ороод тэнцээгүй учир зөвшөөрөл олгоогүй Л.Шинэцэцэгийг БСШУ-ны сайдын 2004 оны 38 дугаар тушаалаар АНУ-ын Хавайн их сургуульд түүхийн ухааны магистрантурт суралцуулахаар шийдвэрлэн 32.0 мянган ам.доллар;
- Сонгон шалгаруулалтад тэнцээгүй, дээрх зөвлөлөөр хэлэлцээгүй байхад Л.Ундрамыг БСШУ-ны сайдын 2004 оны 244 дүгээр тушаалаар Англи улсын

Шеффелдийн их сургуулийн магистрантурт суралцуулахаар шийдвэрлэн 48.0 мянган ам.доллар;

- Дээрх зөвлөлийн 2004.07.15-ны өдрийн хурлаар хэлэлцээд зөвшөөрөөгүй атал С.Өлзийхутагийг БСШУ-ны сайдын 2005 оны 393 дугаар тушаалаар Англи улсын Лондон хотын Метрополитений их сургуулийн магистрантурт суралцуулахаар шийдвэрлэн 16.0 мянган ам.доллар тус тус олгосон байна.

3.17. Т.Энхцэцэгийг АНУ-ын Де Врай ИС-д 2 жил суралцуулахаар гаргасан тушаалыг Английн Букенгемийн ИС-д 1 жил, АНУ-ын Де Врай ИС-д суралцуулах болгон 2 дахин, М.Загдсүрэнг АНУ-ын Калифорны ИС-д 2 жил суралцуулахаар гаргасан тушаалыг Лондонгийн Технологи менежментийн ДС-д 1,5 жил суралцуулах гэх мэтээр 30 гаруй хүний суралцах улс, сургууль, мэргэжлийг солих, хугацааг өөрчлөх тушаалыг БСШУ-ны сайд 2004-2006 онд гаргасан нь дээрх зөвлөл сургалтад хамрагдахаар ирүүлсэн материалыг сайтар хянаагүйг харуулж байна.

3.18. БСШУ-ын сайдын 2001 оны 117 дугаар тушаалын 17, 2005 оны 52 дугаар тушаалын 18-д “өндөр хөгжилтэй орны магистрантур, бакалаврын сургалтад хичээлийн нэг жилд нэг өрхөөс зөвхөн нэг суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох”-оор заасныг зөрчин 22 өрхийн тус бүр 2-3 буюу нийт 46 хүүхдийг суралцуулсан байна.

3.19. Тухайлбал, нэг гэр бүлийн хүүхдүүд болох Нямгаваагийн Сарнай, Лянхуа нарын сургалтын төлбөрт 56.4 мянган ам.доллар, Сэрээтэрийн Эрдэнэчимэг, Эрдэнэтуул, Ононгийн Алтан, Мичид, Элдэвсүрэнгийн Дамдиндорж, Ариунгэрэл, Содномдоржийн Санасэр, Дамбий, Нацагдоржийн Билгээ, Сэвжид нарын сургалтын төлбөрт өрх бүрт 64.0 мянган ам.доллар, Чинчулууны Раднаабазар, Алтан нарын сургалтын төлбөрт 80.0 мянган ам.доллар, Чулууны Гэрэлтуяа, Саруултуяа нарын сургалтын төлбөрт 55.1 мянган ам.доллар, Намсрайн Ариунаа, Намуужин нарын сургалтын төлбөрт 50.1 мянган ам.доллар олгосон боловч зээлээ төлөөгүй, 14 нь эх орондоо ирж захиалгат байгууллагадаа ажиллаагүй байна.

3.20. Дээрх 46 суралцагчаас 938.7 мянган ам.долларын сургалтын зээл авсан 22 суралцагч нь суралцах хугацаа дууссан ч эх орондоо ирээгүй ба БСШУ-ын сайдын 2001 оны 117 дугаар тушаалын 4, 2005 оны 52 дугаар тушаалын 5-д “зарласан мэргэжлийн чиглэлийн дагуу 2-оос доошгүй жил ажилласан байх”-аар заасныг зөрчин Гардийн Тэнүүнд 17.0 мянган ам.доллар, Сандагдоржийн Болдод 34.0 мянган ам.доллар, Содномдоржийн Дамбид 32.0 мянган ам.доллар, Энхтүвшингийн Булганд 5.0 мянган ам.долларын сургалтын зээл олгосон ба зээлийн төлбөрөө бүгд төлөөгүй байна.

3.21. Энхтүвшингийн Булганыг ОХУ болон Англи улсад, Дэмбэрэлийн Нямцэрэнг ОХУ болон АНУ-д тус бүр 2 удаа магистрантур, докторантурт суралцуулахад 32.0-20.5 мянган ам.долларын сургалтын зээл олгожээ.

3.22. Үндсэн сургалтад хэлний бэлтгэлтэй хүмүүсийг суралцуулах журамтай атал АНУ, Англи, ОХУ, ХБНГУ, Украин, Швейцари, Польш, Австри зэрэг орнуудад 102 суралцагчийг хэлний бэлтгэлд суралцах, төгссөний дараа дадлагажих сургалтад хамруулахаар гэрээг сунган 1,019.6 мянган ам.долларын зээлийг журам зөрчин илүү олгожээ.

3.23. СТС-гийн хөрөнгөөр өндөр хөгжилтэй орнуудын топ 500 сургуульд суралцуулах БСШУЯ-ны бодлого бий гэх авч дээрх сургуулиудын жагсаалтад байхгүй БНХАУ-ын Хэбэй мужийн ИС, АНУ-ын Брижпортын ИС, Де Врай ИС, Английн Холборн коллеж, Австралийн Куртений ИС, ХБНГУ-ын Оснабрукийн гэх зэрэг 178 сургуулийн 331 суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгосон байна.

3.24. Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдыг сонгон шалгаруулахдаа ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн дагуу ойрын 4 жилийн тэргүүлэх чиглэлийг харгалзан хүний тоо, мэргэжлийн чиглэлийг тогтоодог гэх боловч өнгөрсөн хугацаанд дээрх орнуудад суралцсан 924 хүний 112 нь эдийн засаг, 379 нь хууль, эрх зүйн чиглэлээр суралцсан нь бодлого алдагдсаныг харуулж байна.

3.25. Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт ХХААЯ-ны захиалгаар суралцсан 33 хүний 15 нь урьд нь тус салбарт ажиллаж байгаагүй, 6 нь төгсөж ирээд өөр байгууллагад ажиллаж байгаа, ГХЯ-ны захиалгаар суралцсан 32 хүний 22 нь, ЗГХЭГ-ын захиалгаар суралцсан 24 хүний 7 нь, Нийслэлийн ЗДТГ-ын захиалгаар суралцсан 6 хүний 5 нь урьд нь тус салбар болон байгууллагад ажиллаж байгаагүй, ЗГХЭГ-ын захиалгаар суралцагсдаас 6 нь төгсөж ирээд тус байгууллагад ажиллаагүй байна.

3.26. БСШУ-ны сайдын тушаалаар өндөр хөгжилтэй орны магистрантурт 2 жил суралцахаар болж нэг жилийн сургалтын төлбөрийн зээл авсан боловч төлөөгүй, эх орондоо эргэж ирээгүй 46 суралцагч сургуульдаа суралцсан, төгссөн нь тодорхойгүй байна.

3.27. “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2.6-д их сургууль, коллежид суралцагчийн бакалаврын сургалтын зардлыг зээлээр олгох тухай дурдсан нь мөн журмын 1.1 дэх “Өндөр хөгжилтэй орны нэр хүндтэй сургуулиудад магистр, аспирант, докторантын сургалтад хамрагдагсдын сургалтын болон тэтгэлгийн зардлыг санхүүжүүлэхэд энэ журмыг мөрдөнө” гэсэн заалттай зөрчилдөж байна.

3.28. Дээрх зөрчилтэй заалтын дагуу өндөр хөгжилтэй орнуудад бакалаврын сургалтад хамрагдсан 80, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан 39 суралцагчдын сургалтын төлбөрт 1,234.3 мянган ам.долларыг улсаас зарцуулсан ба бакалаврын сургалтад хамрагдсан хүмүүсийн дийлэнх нь суралцах хугацаандаа сурлагын өндөр амжилт гаргасан, сургуулийнхаа шилдэг оюутан болсон, төгсөөд тодорхой ажил хийхээр бэлтгэгдэж байгаа зэрэг шалгуурыг хангасан нотлох баримтгүй байна.

3.29. БСШУЯ Боловсролын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу СТС-гийн хөрөнгийг зарцуулах журмыг ЗГ-аар тогтоолгох, сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох ажлын бодлого, зорилтыг тодорхой болгох ажлыг орхигдуулж, өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцах иргэдийг сонгон шалгаруулах ажлыг хангалтгүй гүйцэтгэжээ.

3.30. Үүний зэрэгцээ БСШУ-ны сайдын тушаалаар байгуулагдсан СТС-гийн Удирдах зөвлөл өнгөрсөн хугацаанд сангийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх, салбарын бодлого чиглэлтэй нийцүүлэн сангийн хөрөнгийн гүйцэтгэлд хяналт тавих үүргээ биелүүлээгүй, 2000 оноос хойш хуралдсан тухай баримт материал алга байна.

3.31. Төрийн байгууллагын гэрээт албан хаагчдын сургалтын төлбөрийг төр хариуцахгүй болсноор сургалтын төрийн санд хамрагдагсдын хүрээ хумигдсан боловч шийдвэрийг цуцалж, ЗГ-ын 2006 оны 55 дугаар тогтоолоор энэхүү арга хэмжээнд 2005-2006 оны хичээлийн жилд 800 гаруй оюутныг хамруулан 439.0 сая төгрөг зарцуулсан нь сургалтын төрийн сангийн бодлогыг тодорхой болгон цогц арга хэмжээ авах шаардлагатайг харууллаа.

3.32. СТС-гийн зэрэгцээ АМГТХЭГ-т тус салбарын боловсон хүчнийг бэлтгэх сургалтын санг “СОКО Интернейшнл” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу байгуулж, үйл ажиллагааг нь ҮХ-ны сайдын болон тус газрын даргын тушаалаар батлагдсан журмаар зохицуулж байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийг суралцагчдад олгох шалгуур үзүүлэлт боловсронгуй бус, төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид суралцагсдын сургалтын төлбөрийг тооцох нэгдсэн аргачлал мөрдүүлээгүй, өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг зохих ёсоор тогтоогоогүй байна.
- Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн үр дүнг тооцох аргачлал, журам тодорхой бус байна.
- СТС-гийн бодлого тодорхой бусаас шалтгаалан сургалтын зээл, буцалтгүй тусламжид хамрагдагсдын хүрээ хэт өргөжсөн бөгөөд зээлийг төлүүлэх оновчтой механизм алга байна.

Холбогдох байгууллагын санал


**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

210620а Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 32-31-58
E-mail: mecs@mecs.pmis.gov.mn
Web address: http://mecs.pmis.gov.mn/

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

2007.12.24 № 10/6942
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танай 2007 оны 2/436 тоот албан бичгээр ирүүлсэн Сургалтын төрийн сангийн зарим үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Монгол Улсын иргэдийг гадаадын өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах үйл ажиллагааг Улсын Их Хурлын санаачилгаар 1997 оноос эхлэн тус яамнаас хэрэгжүүлж байгаа бөгөөд 2007 оны 12 сарыг хүртэл гадаадын 32 улсад 1100 оюутан, магистрант, докторантыг суралцуулаад байна.

Суралцагчдын сургалтын зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу тухайн суралцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байгуулсан зээлийн гэрээний дагуу суралцаж буй сургуулийнх нь дансанд бэлэн бусаар шилжүүлэх замаар санхүүжүүлж байна.

Сургалтын төлбөр болон суралцах хугацаа нь улс, сургууль, түвшин, мэргэжлээсээ хамаараад янз бүр байдаг тул 1999 оныг хүртэл суралцагч бүрт өөр хэмжээний зээл олгодог байсныг өөрчилж, санхүүжилтийг шударга хууваарилах, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор тухайн жилд тус яам, АНУ-ын Колорадогийн их сургууль хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд заасан нэг жилийн сургалтын зардал болох 16000 ам.доллар (үүнээс 8000 нь сургалтын төлбөрт, үлдсэн 8000 нь амьжиргааны тэтгэлэгт)-ыг нэг суралцагчид нэг жилд олгох зээлийн жишиг хэмжээ болгон Сургалтын төрийн сангаас үйл ажиллагаандаа мөрдөж байгаа болно.

"Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-д зааснаар суралцагч хугацаандаа төгсөж чадаагүй, төгсөөд эх орондоо ирээгүй, гэрээнийхээ дагуу ажиллаагүй бол зээлээ өөрөө буюу итгэмжлэгдсэн төлөөлөгч нь төлөх ба төлбөрийг барагдуулах асуудлыг Сургалтын төрийн сан хариуцан гүйцэтгэнэ гэж заасан байдаг. Энэ үүргийнхээ дагуу СТС нь 2003 оноос уг асуудлыг хариуцсан хуулийн мэргэжилтэн авч ажиллуулах, суралцагчдын барьцаалсан хөрөнгийг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт тэмдэглүүлэх, захиалагч байгууллагаар нь дамжуулан суралцагч, төгсөгчдөө бүртгэх зэрэг ажлуудыг зохион байгуулаад байна.

Зээлийн өрийн төлбөрийг барагдуулах ажлыг суралцагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, СТС, захиалагч хооронд байгуулдаг гэрээний 3.3-ын

10 7438

Тайлбар
1-ийг
үзнэ үү

дагуу мөн захиалагч байгууллага хариуцдаг. Энэ үүргээ биелүүлж, төлбөрийг барагдуулах талаар СТС-гаас бүх захиалагч байгууллагууд руу албан тоотууд явуулсан боловч, одоогоор дорвитой арга хэмжээ аваагүй байна. Энэ ажлыг эрчимжүүлэхэд захиалагч байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх асуудал чухал байна.

Өндөр хөгжилтэй оронд СТС-гийн зээлээр суралцагчдыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам"-ын дагуу захиалагч байгууллагууд нь бие даан шалгаруулж байгаа тул өөрийн захиалгаар суралцах хүнээ зөв сонгох, шалгаруулалтыг нээлттэй шударга зохион байгуулах, сургалтын явцад хяналт тавих, буцаан ирүүлэх, шаардлагатай нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, гэрээнд заасан ажлын байраар баталгаатай хангах тал дээр анхаарах нь зүйтэй юм.

Тайлбар
2-ыг
үзнэ үү

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүрт олгогдсон сурч боловсрох эрхийн дагуу өнгөрсөн 11 жилийн хугацаанд зарим өрхөөс 2-3 гишүүн суралцсан тохиолдлууд гарсан байна. Энэ асуудлыг журмаар зохицуулах нь хүндрэлтэй боловч санхүүжилтийг шударга хууваарилах, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 117, 2005 оны 52 дугаар тушаалаар тус тус батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам"-д энэ талаар заалт оруулж өгсөн. Ингэснээр нэг хичээлийн жилд нэг өрхөөс 1-ээс дээш суралцагч элсэх асуудлыг зогсоосон.

"Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам"-д энэ санхүүжилтийг зөвхөн дэлхийн шилдэг 500 сургуульд элсэгчдэд олгохоор заасан боловч эдгээр сургуулиудын сургалтын төлбөр, амьжиргааны зардал, элсэлтийн шаардлага зэрэг нь хэт өндөр байдгаас манай иргэдийн амьжиргааны болон суралцах бэлтгэлийн байдал, захиалагч байгууллагын саналыг харгалзаж үзэхээс өөр аргагүй болдог тул энэ жагсаалтад ороогүй зарим сургуульд суралцагчдад санхүүжилт олгосон байна. Мэргэжлийн чиглэлийн хувьд ч мөн тухайн захиалагч байгууллагын саналыг харгалздаг юм.

СТС-гийн санхүүжилтийг сургуулийн дансанд бэлэн бусаар шилжүүлэх замаар суралцагчдад зээлийн хэлбэрээр олгодог бөгөөд тухайн иргэн нь захиалагч байгууллага, СТС-тай байгуулсан гэрээнийхээ дагуу энэ зээлийн төлбөрийг бүрэн барагдуулах үүрэг хүлээж, үл хөдлөх хөрөнгө барьцаалдаг. Гэхдээ Улсын Их Хурлаас санаачлан хэрэгжүүлж буй энэ арга хэмжээний гол зорилго нь суралцагчдын авсан зээлийн төлбөрийг цагдаа, шүүхийн байгууллагаар барагдуулж, түүгээр нь Сургалтын төрийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг арвижуулах ажил биш юм. Харин төрийн албыг өндөр боловсрол, соёлтой, гадаад хэлний мэдлэгтэй хүмүүсээр бэхжүүлэх ажил гол зорилго нь байсан боловч зарим суралцагч, захиалагч байгууллага нь үүрэг хариуцлагаа дутуу ухамсарлаж байгаа тул энэ ажилд зарим дутагдал, доголдол гарсан байна. 2005 онд шинэчлэгдсэн журмын дагуу сүүлийн 3 жилд сонгон шалгаруултыг захиалагч байгууллагууд бие даан гүйцэтгэж байгаа боловч байдал сайжрах төлөвгүй хэвээр байна.

Иймд тус яамнаас "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлуулан Хууль зүй, дотоод

Тайлбар
3-ыг
үзнэ үү

хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна. Харин суралцагчдыг санхүүжүүлэх журам болон СТС, захиалагч байгууллагатай байгуулдаг гэрээний загварыг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулж, 2008 оны эхний хагас жилд багтаан Засгийн газрын тогтоолоор батлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар байгуулагддаг "Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлыг зохицуулах зөвлөл" нь тус яам, ЗГХЭГ, Сангийн яам, СТС-ийн төлөөллөөс бүрдэх бөгөөд "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам"-ын 11, 14-ийн дагуу журмын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай зөвлөмж, зохицуулалтаар хангах, сонгон шалгаруулалтын дүнг танилцуулах үүрэг хүлээдэг ба "Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6-г зохицуулах ажлыг хариуцан гүйцэтгэдэг юм. Цаашдаа энэ зөвлөлийг хэрхэн байгуулах, ямар бүрэлдэхүүнтэй байх, ямар эрх, үүрэг хүлээх, хэрхэн ажиллах зэргийг журамлах асуудлыг судалж боловсруулах болно.

Хүндэтгэсэн,



Н.Болормаа

Н.БОЛОРМАА

МОНГОЛ УЛС БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ СУРГАЛТЫН ТӨРИЙН САН

2007 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот
Утас: 324384, 324598
Факс: 976 11 324384

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТИЙН ГАЗРЫН НЭГДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ГАНБИЛЭГ ТАНАА


Төрийн аудитийн тухай хуулийн
19.3.1-д заасны дагуу
санал хүргүүлэх тухай


Монгол улсын Үндэсний Аудитийн газраас СТС-ийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай уншиж танилцаад дараах хоёр саналыг хүргүүлж байна.

- Тайлангийн 1.2-т заасан 2005-2006, 2006-2007 оны хичээлийн жилд олгосон зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагчдын тоог харуулсан хүснэгт тус тайланд ташаа туссаныг залруулж дараах байдлаар нарийвчлан тусгах саналтай байна.

Үзүүлэлт		2004	2005-2006			2006-2007				
		Оюутны тоо	нэмэгдсэн	хасагдсан	авах	авсан	нэмэгдсэн	хасагдсан	авах	авсан
Мэргэжлийн боловсролын сургуульд хөнгөлөлтэй зээл, буцалтгүй тусламжаар суралцагчид /96-р тогтоолоор/	хөн зээл	9494	1845	2700	8639	8696	1845	2159	8382	8460
	буцалтгүй тусламж	1897	367	126	2138	2149	367	155	2361	2377
	шагнал, олимпиад	137	28	41	124	126	28	21	133	139
	дүн	11528	2240	2867	10901	10971	2240	2335	10876	10976
Мэргэжлийн боловсролын сургуульд буцалтгүй тусламжаар суралцагчид /158-р тогтоолоор/	нэн ядуу	11913	2219	1671	12461	12507	2219	2634	12092	12156
	малчин	5034	937	915	5056	5077	937	1236	4778	4808
	3-н суралцагч	1095	204	282	1017	1020	204	289	935	941
	дүн	18042	3360	2868	18534	18604	3360	4159	17805	17905
ДҮН	29570	5600	5735	29435	29575	5600	6494	28681	28881	
Мэргэжлийн боловсролын сургуульд Засгийн газрын 201-р тогтоолоор суралцагчид		17483	3339	4465	16357	16428	4295	4154	16569	16665
БҮГД ДҮН		47053	8939	10200	45792	46003	9895	10648	45250	45546

- Тайлангийн 1.3-т заасныг БСШУ-ны сайд, СЭЗ-ийн хамтарсан тушаалаар тогтоосон хяналтын тооноос 2005-2006 онд **140**, 2006-2007 оны хичээлийн жилд **200** суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж хэтрүүлж олгосноор дээрх хүснэгтээс залруулах. Бидний саналыг нягтлан тус тайланд тусгаж өгөхийг хүсье.



ЗАХИРАЛ  П.ЛХАГВАСҮРЭН

Тайлбар
1-ийг
үзнэ үү

Саналд өгөх тайлбар

БСШУЯ-ны саналд өгөх тайлбар

Тайлбар 1

1999 оноос БСШУЯ, АНУ-ын Колорадогийн их сургуулийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд 1 жилийн сургалтын зардлыг 16.0 мянган ам.доллар байхаар тусгасан гэх боловч аудитын явцад уг гэрээ байгаагүй, үүнийг мөрдөх талаар Санхүү, төсвийн болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын албан ёсны шийдвэр алга байна.

Тайлбар 2

БСШУ-ны сайдын 2001 оны 117, 2005 оны 52 дугаар тушаал гарснаар нэг хичээлийн жилд нэг өрхөөс 1-ээс дээш суралцагч элсэх асуудлыг зогсоосон гэх боловч 2002 онд Ононгийн Алтан, Мичид, Чинчулууны Алтаннар, Раднаабазар, 2003 онд Элдэвсүрэнгийн Дамдиндорж, Ариунгэрэл, 2004 онд Нацагдоржийн Билгээ, Сэвжид нарын нэг өрхийн суралцагчид сургалтын төлбөрийн зээл авсан байна.

Тайлбар 3

Сургалтын зээлийн төлбөрийг барагдуулж СТС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг арвижуулах нь тус сангийн гол зорилго биш гэж саналд дурджээ. Гэтэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд сургалтын зориулалттай зээлийн төлбөр нь Сургалтын төрийн сангийн хөрөнгийн эх үүсвэр байхаар, “Их, дээд сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”-д олгосон зээл, түүний хүүгийн төлбөрөөс орох орлогыг СТС-гийн эх үүсвэрт тооцохоор заасан байна. Сан эх үүсвэрээ бүрдүүлэхэд анхаарах ёстой.

СТС-гийн саналд өгөх тайлбар

Тайлбар 1

Саналыг хүлээн авч тайлангийн 1.2, 1.3-т тусгав.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөмж болгож байна.

Сангийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа нарт:

- “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 7.1.2-т СТС нь “Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад дотоодын аж ахуйн нэгж, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж хандив”-аас бүрдэхээр заасныг үндэслэн АМГТХЭГ дахь сургалтын санг СТС-нд нэгтгэх асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад:

- Оюуны чадавхи сайтай боловч төлбөрийн чадваргүй оюутнуудыг дэмжих чиглэлээр СТС-гийн бодлогыг тодорхой болгох, сургалтын зээл, буцалтгүй тусламжийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдүүлэх,
- СТС-гаас сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох шалгуур, их, дээд сургууль, коллежийн нэг суралцагчид ногдох сургалтын зардлын жишгийг боловсронгуй болгох, өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцуулах оюутны тоо, олгох зээлийн хэмжээг зохих ёсоор тогтоох

Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэнд:

- Сургалтын зээлийг төлүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах

№	Зөвөлгөл байгууллага	Ихт суралт эзтэйчүүдийн тоо	Ажлын эрхлэлт ААН	Үндэс				Хүснэгт	Ажлын эрхлэлт ААН	Ажлын эрхлэлт ААН	Үндэс				Ажлын эрхлэлт ААН	Ажлын эрхлэлт ААН	Ажлын эрхлэлт ААН	Үндэс																			
				Хүснэгт		Хүснэгт					Хүснэгт		Хүснэгт					Хүснэгт		Хүснэгт		Хүснэгт		Хүснэгт													
				Тоо	Аян	Тоо	Аян				Тоо	Аян	Тоо	Аян				Тоо	Аян	Тоо	Аян	Тоо	Аян	Тоо	Аян	Тоо	Аян										
1	МОНП	3	54000.0															3	54000.0					1	8000.0	14.3	2	48000.0	85.7								
2	МОНП	27	238227.8															22	581625.9	29.6	12	302000.0	40.9	10	285625.9	38.7											
3	МОНП	42	1081263.0															26	620329.8	58.4	12	349894.0	24.2	14	363458.8	34.2											
4	БСНПР	279	707902.4	1	32800	1	47032.00	0.7	90	231954.1	31.8	65	163834.2	23.4	13	361418.8	5.1	12	372174.0	5.3	187	4618036.4	65.5	74	1825476.8	25.8	113	2782559.6	39.8								
5	БСНН	60	1526277.6															40	994075.2	62.4	23	536646.0	33.7	17	457829.2	28.7											
6	БСНН	89	1544995.4	1	10000													33	628220.4	41.3	24	436630.2	28.3	9	91590.2	13.0											
7	ӨВР	31	597902.9															22	41872.3	74.2	7	187060.0	31.3	15	254812.3	43.0											
8	ӨВР	67	1466281.6															49	1018388.3	68.8	20	388023.9	26.5	29	620384.4	42.3											
9	БОН	27	746860.2															22	594369.2	79.6	8	168591.0	22.7	14	424510.2	56.8											
10	ЭКОР	15	352124.0															10	228538.3	64.9	4	76462.0	21.6	6	152396.3	43.3											
11	ӨМӨ	75	1893881.8															45	1179912.4	62.3	16	399494.2	24.1	29	780418.2	41.2											
12	Бүс, ХААН	32	741826.4															25	577249.3	77.8	8	156599.0	20.3	17	426440.3	57.5											
13	ЭВАР	17	325302.7															11	195090.7	60.0	5	98200.0	30.1	6	97092.7	29.8											
14	БОН	17	324142.5															13	226617.9	71.2	7	110503.9	34.1	6	128144.0	37.1											
15	ӨНӨ	13	310918.0															12	289021.0	94.0	7	162060.0	52.1	5	124861.0	38.9											
16	БОН	13	302110.3															7	158521.3	52.5	5	120739.3	40.0	2	37782.0	12.5											
17	ҮНӨТ	6	424281.8															6	124281.8	100.0	4	84281.8	67.8	2	40000.0	32.2											
18	ТТГазар /	15	91460.0															11	69860.0	76.4	4	5866.0	58.7	3	16200.0	17.7											
19	ҮНӨТ	54	521777.0	1	600	34	31003.00	5.9	3	87341.2	16.7	2	64000.0	12.3			16	397032.8	77.3	6	124345.0	23.8	10	272687.8	53.5												
20	Өмчлөл Банк	16	421265.5															11	261937.4	62.7	7	146670.0	34.8	4	117267.4	27.8											
21	Шүүж	2	40000.0															2	40000.0	100.0	2	40000.0	100.0														
22	Улсын Ерөнхий прокуратура газар	2	21307.7															2	21307.7	100.0	2	21307.7	100.0														
23	Үндсэн хурлын өрх	1	8000.0															1	8000.0	100.0	1	8000.0	100.0														
24	МҮ-ийн Ерөнхий сайд	11	208431.2															6	124076.2	59.5	3	78518.2	37.7	3	45588.0	21.9											
25	МҮ-ийн Шөвөр сайд	3	101637.0															2	64000.0	63.0					2	64000.0	63.0										
26	Уяа Стат газар	5	89570.0															4	57570.0	64.3	3	5600.0	62.5	1	1570.0	1.8											
27	Агууны бодлого	1	2500.0															1	2500.0	100.0	1	2500.0	100.0														
	ДҮН	903	20264395.4	31	48100	37	12077.88											294	2028454.4		38	1029067.2		30	291117.7		276	518269.5		319	772323.3						

Помню, Орос улсад сураалцахыг төлсөөт 370459.27

Нийт төлсөө: 21134054.65

Үндэстэй эртэй газар



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сургалтын төрийн сангийн зарим үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр, Сангийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэн нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2008 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэн нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА